



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 675

Улаанбаатар хот

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлага тус бүрийн ажлын байрны тодорхойлолт, мэргэжил, ажлын туршлага, томилсон тогтоол, шийдвэрийг цахим хуудсандаа ил тод, нээлттэй байршуулж, олон нийт танилцах, хяналт тавих боломжийг бүрдүүлэхийг Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал болон төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх захирал нарт даалгасугай.

2.Ногдол ашгийн бодлогын шинэчлэлийн хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 100 хувь хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж буй Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн 2021 оны жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангаар тодорхойлсон цэвэр ашгийн 50 хувь, эсхүл төрд ногдох эздийн өмчийн 1 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр хэмжээгээр төрийн өмчийн ногдол ашгийг тооцож, 2022 оны II дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

3.Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг хэмжих санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн маягтыг шинэчлэн, санхүүгийн үр дүнг номинал дүнгээс гадна санхүүгийн харьцааны үзүүлэлтээр хэмжих, бодитой төлөвлөх, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх, хуулийн этгээдийн төсөвт төвлөрүүлсэн ногдол ашгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэн тэргүүнд харгалзан үзэх чиглэлийг тусган шинэчлэн боловсруулж, батлуулахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

4.Төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчдэд дараах зүйлийг зөвлөмж болгосугай. Үүнд:

а) Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагыг нээлттэй сонгон шалгаруулах, тухайн ажлын байрны тодорхойлолт, тавигдах шаардлага, сонгон шалгаруулсан талаарх үнэлгээний тайлан, томилсон тогтоол,

шийдвэрийг компанийн цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулж, олон нийт танилцах, хяналт тавих боломжийг бүрдүүлж ажиллах.

б) Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд заасан төсвийн хэмнэлтийн бодлогыг баримтлан орлого, ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэхгүй тохиолдолд зардлыг өмнөх оны түвшинд царцааж, ашигт ажиллагаа, орлого өгөөжийн түвшинг сайжруулах шинэчлэл хийх үйл ажиллагааг тусган хэрэгжүүлэхийг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх захирал нарт үүрэг болгох.

в) Ногдол ашгийн бодлогын шинэчлэлийн хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн 2021 оны жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангаар тодорхойлсон цэвэр ашгийн 50 хувь, эсхүл төрд ногдох эздийн өмчийн 1 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр хэмжээгээр төрийн өмчийн ногдол ашгийг тооцон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, төсөвт ногдол ашгийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах, Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын 2022 оны ажлын үр дүнг үнэлж, дүгнэхдээ тухайн хуулийн этгээдийн төсөвт төвлөрүүлсэн ногдол ашгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэн тэргүүнд харгалзан үзэх.

г) Дамжуулан зээлдүүлэх гэрээний эргэн төлөлтийг хэрхэн төсөвт тусгах, төлж барагдуулах хуваарийг тодорхой болгох.

д) Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал (зорилтын санал)-ын төслийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан хугацаанд Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлэхийг гүйцэтгэх удирдлагуудад үүрэг болгох.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ